

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил	3
ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	5
ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	9
3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл	9
3.2 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт	10
3.3 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж	11
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
4.1 Зорилго	13
4.2 Зорилт	13
4.3 Хамрах хүрээ:	13
4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт	14
4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө биелэлт	15
4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө биелэлт	15
4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт	15
4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө биелэлт	15
4.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө биелэлт	18
ДҮГНЭЛТ	19
ХАВСРАЛТ 1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ	20
ХАВСРАЛТ 2 НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ	21
ХАВСРАЛТ 3 ОСОЛ ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ	22
ХАВСРАЛТ 4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ	23
ХАВСРАЛТ 5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Химийн бодисын агуулахын талбайн солбицол	3
Хүснэгт 2 Агуулахад хадгалах химийн бодис	5
Хүснэгт 3 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа	9
Хүснэгт 4 Төслийн гол сөрөг нөлөөлөл	10
Хүснэгт 5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	11
Хүснэгт 6 2025 оны БОМТ-ний гүйцэтгэлийн нэгтгэл мөнгөн дүн	13
Хүснэгт 7 Сөрөг нөлөөлөл бууруулахад авсан арга хэмжээ	14
Хүснэгт 8 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлсэн арга хэмжээ	15
Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	15

Хүснэгт 10 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө биелэлт	16
Хүснэгт 11 Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдэлийн төлөвлөгөө биелэлт	17
Хүснэгт 12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Төслийн талбайн байршил	3
Зураг 2 Төслийн талбайн өнөөгийн нөхцөл байдал	7
Зураг 3 Химийн бодисын агуулах	7
Зураг 4 Химийн бодисын агуулах	8

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төслийн нэр:	“Химийн бодис хадгалах, худалдаалах агуулах”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Аз саплай” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011457005
Регистрийн дугаар:	5788692
Хаяг:	Улаанбаатар, Баянгол, 1-р хороо, 2-р хороолол, Хатанбаатар Магсаржав, 015,14 тоот
Утас:	99118545

1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил

Тус компани нь гадаад, дотоод худалдаа, барилгын материалын худалдааны чиглэлээр үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд барилгын үйлдвэрлэлд хэрэглэдэг хөнгөн блокийн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох Хөнгөн цагаан /нунтаг/, Хөнгөн цагааны /паста/-г БНХАУ, ОХУ-аас импортлон худалдаалахаар зорьсон байна.

Үйлдвэрлэлийн зориулалт Хөнгөн цагааны пигмент, эмаль, лак зэргийг үйлдвэрлэлийн зориулалтаар дараах хөнгөн цагаан /нунтаг/, Хөнгөн цагааны /паста/-ыг ашиглагддаг юм.

Хүснэгт 1 Химийн бодисын агуулахын талбайн солбицол

№	X	Y	Урт	Цэг
1	672576.83	5293877.39	167.93	1-2
2	672743.28	5293899.61	0.00	2-3
3	672743.28	5293899.61	42.78	3-4
4	672772.20	5293868.09	251.70	4-5
5	672600.63	5293683.93	194.93	5-1



Зураг 1 Төслийн талбайн байршил

ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

“Азсаплай” ХХК нь барилгын материалын Бетон блокийн түүхий эд болох хөнгөн цагааны пудрийг жилд 340тонн ОХУ-аас оруулж ирнэ. Импортлох химийн бодисын мэдээллийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 2 Агуулахад хадгалах химийн бодис

№	Химийн бодисын нэр	Олон улсын нэршил	Томьёо	CAS дугаар	1 жилд Оруулж ирэх хэмжээ
1	Хөнгөн цагааны нунтаг	Aluminum powder	Хөнгөн цагаан AL	7429-90-5	170 тонн
			Стеарин /stearic acid/ CH3(CH2)16COOH	57-11-4	
2	Хөнгөн цагааны паста	Aluminum pasta	Хөнгөн цагаан	7429-90-5	170 тонн
			Октаденовын хүчил	57-11-4	
			2,2-Оксидиэтанол	111-46-6	
Нийт					340 тонн
Хөнгөн цагааны нунтаг			Хөнгөн цагааны паста		
Савласан харагдах байдал					
					
Нунтаг харагдах байдал					
					

Төслийн дэд бүтцийн шийдэл:

Ажиллах хүч:	Тус химийн бодисын агуулах нь нийт 4 ажилтантай бөгөөд Гэрээт ачигч-2, Нярав-1, Гэрээт харуул-1 гэсэн бүтэц зохион байгуулалттай ажиллаж байна.
Газар ашиглалт:	“Аз саплай” ХХК-ийн химийн бодисын агуулах нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 4-р хороонд, 21732м ² талбай эзэмшлийн /нэгж талбарын дугаар 18672295739978/ талбайд үйл ажиллагаагаа явуулж байна.
Цахилгаан хангамж:	Цахилгаан эрчим хүчний хэрэгцээг төвлөрсөн эх үүсвэрээс хангана.
Зам харилцаа:	Төсөл хэрэгжих буй газар нь харилцаа холбооны бүх үүрэн операторуудын сүлжээ сайн барьдаг налайх төв замаас 300м зайтай байна.
Халаалт:	Төвлөрсөн эх үүсвэрээс хангана.
Ус хангамж:	Гүний худгаас усны хэрэгцээг хангана. - Гүний худгийн солбицол 47°46'29.32"N, 107°18'16.94"E - Цооногийн гүн 80м - Усны тогтсон түвшин 51м - Цооног ашиглалтын усны ундрог 2.0 л.с Цооног өрөмдсөн диаметр 0м-ээс 80м хүртэл ф159мм
Хог хаягдал:	Төсөл хэрэгжүүлэгч нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын дагуу хог хаягдлын хураамжийн төлбөрийг төлөн ахуйн хог хаягдлыг тээвэрлүүлж байна
Аюултай хог хаягдал:	Төсөл хэрэгжүүлэгч нь “Элемент” ХХК-тай 2024 оны 02 сарын 22-ны өдөр Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээг байгуулан химийн бодисын сав баглаа боодлыг тээвэрлүүлэн устгуулахаар төлөвлөсөн.



Зураг 3 Химийн бодисын агуулах



Зураг 4 Химийн бодисын агуулах

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Химийн бодисыг тээвэрлэх явцад алдаа гаргаж асгах, хөрсөнд алдах, бодисуудын битүүмжлэл алдагдах, бодисууд хоорондоо холилдох, үүнээс үүдэлтэй бодисын ууршилт үүсэх, агаар орчин болон хөрсөн бүрхэвч химийн бодисоор бохирдох.
- Бодисоор бохирдсон хаягдлыг ил задгай хаясан тохиолдолд гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Хийн хаягдал (машин техникээс гарах хий, бодисын ууршилт явагдах үед гарах хий) агаар орчныг бохирдуулах

Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал, агаар байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

Төслийн гол сөрөг нөлөөллийг химийн бодис импортлохоос эхлэн худалдан борлуулах хүртэлх бүхийл үе шатанд авч үзэв. Үүнд богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд, тэдгээрийн эрчим, хамрах хүрээ, хугацаа нь үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын арга, хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийн сонголт зэрэгтэй ихээхэн хамааралтай байна. Төслийн үйл ажиллагааны явц дахь нөлөөлөл нь үйл ажиллагаа эрхлэгчдийн ажлын туршлага, дүрэм журмын хэрэгжилт зэргээс ихээхэн хамаарна.

Хүснэгт 3 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1.	Химийн хортой аюултай бодисын хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, ургамал, гүний ус	Агуулахын нөлөөллийн бүсэд	Боломж бага	Намар, зуны улиралд
2.	Химийн хортой аюултай бодисын буруу хадгалалт	Агаар, ус, хөрс, хүн	Агуулахын ойр орчим	Их	Төслийн хэрэгжих хугацаанд
3.	Химийн хортой аюултай бодисын тээвэр	Агаар, хөрс, хүн	Төслийн хэмжээнд	Дунд	Төслийн хэрэгжих хугацаанд

Эндээс үзэхэд тус төсөл хэрэгжүүлэгч хамгаалалтыг сайжруулах, авто хэрэгслийг зөвхөн тогтоосон замаар явуулах шаардлагатай. Анхаарал болгоомжгүй байснаас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамлын нөмрөгийг талхагдалд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдох нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр хатуу хучилтаас гадуур зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал, химийн бодис асгарах нь хөрс, усны бохирдол, ургамал бохирдуулах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Хүснэгт 4 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Үйл ажиллагаа	Химийн бодисын гол сөрөг нөлөөлөл	
	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
Химийн бодисын хоруу чанараас	- Арьс, нүд хамар хоолойг цочроох - Залгивал хортой, урагт нөлөөлж болзошгүй - Удаан амьсгалбал амьсгалын замын эрхтэн системийг гэмтээж болзошгүй	- Усан орчинд нөлөөлөл үзүүлэх - Усны амьтдад нөлөөлөх - Усан орчны организмд удаан хугацаагаар нөлөөлнө.
Агуулахын үйл ажиллагаанаас	- Ажиллагсад химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар мэдлэггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй ажиллах үед бодис асгарах, нүдэнд хүрэлцэн цочроох, хурц болон ужиг архаг хордлого зэрэг эрсдэл үүсэж болзошгүй - Төслийн үйл ажиллагааны явцад ажиллагсдын анхаарал болгоомжгүй үйл ажиллагааны улмаас бодис асгарах улмаар галын аюул үүсвэл шаталтын дунд хорт хий ялгаруулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. - Ажиллагсдын дотоод журмын зөрчил, ажлын хариуцлага алдах зэргээс дээрх эрсдэл үүсэж болзошгүй.	- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол аюулын улмаас химийн бодис уурших замаар агаар, хөрсний хими, физик шинж чанарыг өөрчлөх, бохирдуулах, орчинд тархах - Химийн бодисын сав баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг журмын дагуу зайлуулж, устгаагүй, ил задгай хаях зэргээс байгаль орчинд бохирдол үүсэж болзошгүй. - Агаарт эвгүй үнэр тархах болон хийн бохирдол үүсгэх

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг баримтлан ажиллаагүй нөхцөлд санамсаргүй асгарч, алдагдсанаас агаар, ус, хөрсийг бохирдуулах, хатуу шингэн хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх, ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх зэргээр богино хугацаанд байгаль орчин болон ажиллагсдын эрүүл мэндэд шууд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эрчмийг нэмэгдүүлж болзошгүй.

3.2 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

Мэргэжлийн байгууллагын зүгээс дараах дүгнэлтийг өгөв. Төсөл хэрэгжих үед байгаль орчин, хүн амд үзүүлэх болзошгүй нөлөөлөл, түүний дотроос химийн бодисоос нөлөөлөх гол сөрөг нөлөөллийг тодруулах зорилгоор химийн бодисын хор аюулын лавлагаа болон төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж тайланг нэгтгэв.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр химийн бодисоос гарч болох гол сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар нэгтгэн урьдчилан тогтоолоо. Үүнд:

- Агуулахад хадгалах химийн бодисууд хоруу чанар амаар “Дунд зэргийн аюултай-2 бодис”, арьсаар “Дунд зэргийн аюултай-1 бодис”, амьсгалаар “Онцгой аюултай-5 бодис”, “Байгаль орчин-Усан орчинд онцгой аюултай-5 бодис тус тус байгаа нь хадгалах болон тариалалтад хэрэглэх үйл ажиллагааны явцад ажилчид хордох болон агуулахын орчны хөрс ус бохирдох эрсдэлтэй байна.
- Компанийн агуулах байр талбайн хүрэлцээ хангалттай байгаа нь химийн хорт аюултай бодисуудыг ангилан хадгалах боломж харагдаж байна. Энэ нь хадгалах явцад болзошгүй гэнэтийн осол гарах, бодисын хурц хордлогод ажилтан өртөх эрсдэл бага байхаар байна.

- Агуулахын орчин нөхцөлийн хувьд агааржуулалт хангалттай бус буюу механик агааржуулалт хэрэглэхээр төлөвлөсөн байгаа нь орчны агаарт химийн бодис шууд цацагдах эрсдэлтэй байна.
- Агуулахын битүүмжлэл муу, дотоод тохижилтод анхаарах шаардлагатай, галын аюулгүй байдлыг хангах шаардлагатай.
- Агуулахын дотоод цахилгааны монтаж галын аюулгүй байдал хангагдаагүй, агуулахын байр стандарт шаардлагад нийцсэн байдал муу байгаа нь цаашид аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй, учрах аюул ослын эрсдэл үүсэх нөхцөл өндөр байна.
- Байгаль орчин хамгаалах үүргийнхээ дагуу агуулахын болон ашиглах талбайн орчны тохижилтыг сайжруулах шаардлагатай.
- Агуулах байршиж байгаа хэсэг хүлэмжийн аж ахуйн хашаанд байрлаж байгаа нь орчны бохирдол, хүн амын өртөлтийн зэрэг нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс агуулахын талбайг тусгайлан хашаалах, харуул хамгаалалт /цоожтой хашаа/ бүхий байлгах, аюулын зурвас шуудуу татаж үерийн ус урсан орохоос сэргийлсэн ажилбаруудыг хийх шаардлагатай.
- Орчинд агаараар химийн бодисын уур, тоосонцор алдахгүй, хамгаалах зорилгоор агуулахын орчноос тодорхой зайд /250-300м/ тойруулан мод суулгах тарьж ургуулсан байх хэрэгтэй.

3.3 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсдад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсэх. Хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийхгүй байх, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс элдэв шавж үржих, халдварт өвчний эх үүсгэвэр болох	- Зориулалтын тусгай цэг тохижуулах - Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлуулах - Хогийн цэгт байнга ариутгал халдваргүйжүүлэлт хийх - Зориулалтын бус газарт шатааж агаар орчин бохирдуулахгүй байх - Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх
2.	Тээврийн хөдөлгөөн ихсэх, хөрс, ургамал талагдах	- Орчны хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, мод тарих, - Тогтоосон замыг засаж сайжруулах, тэмдэглэгээ хийх, явган хүний зорчих замыг хийж тохижуулж, асфальтаар хучих зэрэг арга хэмжээ авах
3.	Химийн бодисоор агаар ус, хөрс бохирдох	- Агуулахын агааржуулалтын ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх, - Бодис хадгалах савыг битүүмжлэл сайтай байлгах

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
		- Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах - Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах - Бодисын хор аюулын талаарх мэдээлэл, танилцуулах самбар тэмдэг тэмдэглэгээг агуулахад ил байршуулах - Химийн бодистой холбоотой сургалт семинар байнга зохион байгуулах - Гадаргын болон газрын доорх усанд алдахгүй байх
4.	Химийн бодист өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	- Химийн ШҮ, химийн бодисын талаар суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах - Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах - Байгальд ил задгай хаяхгүй байх - Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх - Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих - Болзошгүй осол эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, эрсдэл тохиолдсон үед хэрэглэх хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах.
5.	Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдал гарах	- Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах - Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах - Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхгээр нь буцаан татан авч түр хадгалах. - Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хяналттай байлгах - Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах - Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах - Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах - Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй компанид эрх шилжүүлэн хүлээлгэн өгөх. - Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах - Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харъя дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотоор хандан хүргүүлэх - Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд: - Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ - Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

4.2 Зорилт

1. БОЕУ-гээр дүгнэгдсэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
2. Нутгийн уугуул иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцөлийг бүрдүүлж хамтран ажиллах
3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

4.3 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, ан амьтан хамгаалах, үргэж зайлахаас сэргийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 6 2025 оны БОМТ-ний гүйцэтгэлийн нэгтгэл мөнгөн дүн

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Нийт зардал /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,850.0	3,547.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө	3,750.0	5,100.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,260.0	1,920.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,380.0	2,406.7
8	Удирдлага зохион байгуулалт	-	-
9	БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	511.0	206.8
Нийт		15,751.0	13,180.5

4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт

Хүснэгт 7 Сөрөг нөлөөлөл бууруулахад авсан арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар
	1	2	4	5	6	7	8
1	Агаарын чанар	Агуулахын агааржуулалтыг хэвийн ажиллагаатай байлгах	1	-	-	-	Агааржуулалтын автомат системтэй, хэвийн ажиллаж байна. Ухаалаг системээр утаснаас хянаж байна.
2		Бодисыг хамт хадгалах хориотой бодисуудтай хадгалахгүй байх, хаягжуулах	1	-	-	97.0	Хаягжуулалт хийгдсэн.
3		Агуулахад хадгалах химийн бодисд тохирсон гал унтраах хэрэгсэл байршуулах	5	150.0	750.0	950.0	"Итгэл Төгөл Трейд" ХХК-с галын хоруудыг байрлуулсан.
4		Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүд оношилгоог тогтмол хийлгэх	1	100.0	100.0		6594УНЗ 2025.04.13-нд үзлэгт тэнцсэн.
5	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Хөрс бохирдохоос сэргийлж зам талбайг засах, авто зогсоол тохижуулах, тэмдэгжүүлэх	1	1,000	1,000	2,500.0	Өөрсдийн хүн хүчээр хийж гүйцэтгэсэн
6		Хогийн цэгийг хатуу хучилттай болгох, эсвэл хөрсөнд бохирдол алдахгүйгээр зориулалтын плёнкоор тусгаарлаж хайргаар давхарлах	1	1,500.0	1,500		Өөрсдийн хүн хүчээр хийж гүйцэтгэсэн.
7		Хог хаягдлыг тухай бүрд нь ангилан ялгаж арга хэмжээ авах, ангилан ялгах тасалгаат хогийн сав байршуулах.	1	1,500.0	1,500.0		Өөрсдийн хүн хүчээр хийж гүйцэтгэж байна.
8	Гадаргын болон гүний ус	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	1	-	-	-	НБОГ-т хүсэлтийг илгээсэн, хянагдаж байна.
9		Ус ашиглах гэрээ хийх	1	-	-	-	Ус ашиглах дүгнэлт гармагц гэрээ байгуулна.
10		Хаягдал усны дүгнэлт гаргуулах	1	-	-	-	Ус ашиглах дүгнэлт гармагц хүсэлт илгээнэ.
11		Гүний худгийг тоолууржуулах	1	-	-	-	Ус ашиглах дүгнэлт гармагц тоолууржуулна.
Нийт				4,250.0	4,850.0	3,547	

4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө биелэлт

Хүснэгт 8 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7	8
1	Нөхөн сэргээлт	Төслийн таблайд ногоон байгууламж бий болгох /мод тарих, зүлэгжүүлэлт хийх.	м2	200	15.0	3,000.0	4,100.0	"Ногоон Хари" ХХК-тай хамтарч ажилласан.
2		"Тэр бум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд харьяа дүүрэгтэй мод тарих ажилд хамтран оролцох	-	15	50.0	750.0	1,000.0	НД-ийн Байгаль орчны тасаг болон "Баян Арвайн Үр" ХХК-тай хамтарч ажилласан.
Нийт						3,750.0	5,100.0	

4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө биелэлт

Тухайн төсөл хэрэгжих газар нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ба төслийн чиглэл, хүчин чадал, үйл ажиллагаатай холбоотойгоор хүн амыг нүүлгэх шаардлагагүй юм.

4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь суурин бүсэд байрладаг. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд харьяалах орон нутгийн байгаль орчны газар, соёлын өв хариуцан ажиллаж буй ажилтан албан байгууллагад хандан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө биелэлт

Хүснэгт 9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	6	5	7	8	9
1	Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдал зайлуулах гэрээний дагуу ачин зайлуулж байх	Төсөл хэрэгжих талбай	кг	12	140	1,680.0	600.0	Налайх "Тохижилт Үйлчилгээ" ОНӨААТҮГ-тай Хог хаягдлын

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	6	5	7	8	9
		Төслийн хүрээнд дахивар ангилан ялгах, дахиварын цэгт нийлүүлэх.	Төсөл хэрэгжих талбай	кг	-	-	ҮА зардлаар	-	төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажилласан.
2	Технологийн буюу аюултай	Аюултай хог хаягдлыг ахуйн хог хаягдалтай нийлүүлэлгүй мэргэжлийн аж ахуй нэгжтэй гэрээлсэн байх.	Төсөл хэрэгжих талбай	-	-	-	-	1,806.7	"Элемент" ХХК-тай хамтарч ажиллаж байна.
		Аюултай хог хаягдлыг гэрээний дагуу эрх шижлүүлэх, дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах.	Төслийн машин механизм	төг	6	450	2,700.0	-	"Элемент" ХХК-тай хамтарч ажиллаж байна. Бүртгэл хөтлөж байгаа.
		Аюултай хог хаягдлын тайлан гаргаж холбогдох төрийн байгууллагад тайлагнах.	Төслийн хэмжээнд	-	-	-	-	-	Холбоотой байгууллагуудад илгээхэд бэлтгэж байна.
Нийт							4,380.0	2,406.7	

Хүснэгт 10 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7	8
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн	Галын аюулгүй байдлыг хангаж гал унтраах тохирох хор, хэрэгслийг байршуулах	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжид	1	1,000.0	1,000.0	950.0	"Итгэл Төгөл Трейд" ХХК-с авсан
2	шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Агуулахад ажиллах ажилтанд "Галын аюулгүй байдлын сургалт"; "Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт" тус тус сургалтуудад суулгаж сертификатжуулах	Төсөл хэрэгжүүлэгчийн ажилтнууд	4	45	180.0	-	Хийгдээгүй.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7	8
3		Гамшгаас хамгаалах үеийн бэлэн байдлын төлөвлөгөө батлуулж ажиллах	Төслийн хүрээнд	1	-	-		"Налайх Дүүргийн Онцгой Байдлын Хэлтэс"-ээр батлуулсан.
4		Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж хамгаалах хувцас хэрэгслээр хангах	Төслийн хүрээнд	12	90	1,080.0	970.0	"Итгэл Төгөл Трейд" ХХК-с авсан
Нийт						2,260.0	1,920	

Хүснэгт 11 Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдэлийн төлөвлөгөө биелэлт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан
	1	2	3	4	5
1	НБОГ-т	Цаасан тайлан /Цахим тайлан/	БОМТ-ний хэрэгжилт болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	11-р сарын 01	Байгаль орчны менежер
2	БОУАӨЯ-д	Цахим тайлан	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	12-р сар	Байгаль орчны менежер
3	Химийн бодисын тайлан	Цаасан тайлан /Цахим тайлан/	БОУАӨЯ-д	12-р сар	Байгаль орчны менежер
4	Аюултай хог хаягдлын тайлан	Цаасан тайлан /Цахим тайлан/	НБОГ-т	12-р сар	Байгаль орчны менежер
Нийт					

4.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө биелэлт

Хүснэгт 12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Нэгжийн зардал, төг /мян.төг	Нийт зардал, төг /мян.төг/	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	1	2	3	4	5	6	7
Агаарын чанар							
1.1	Агаарын бохирдлын (NO2, SO2, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх /БОТЛ мэргэжилтэн хөлслөн хийлгэнэ. /	Төслийн талбайд	Жилд нэг удаа	2	49.5	99	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдан 2010 оны А/618 дугаар тушаал.
1.2	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Жилд нэг удаа	2			MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
1.3	Дуу шуугиан, чичиргээ: Хүнд даацын машины тээврийн зам, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		Жилд нэг удаа	2			MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Усны хяналт шинжилгээ							
2.1	Усны шинжилгээ – Физик химийн үзүүлэлт	Гүний худгийн ус	Жилд нэг удаа	1	100	100	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2005
2.2	Усны шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/						
2.3	Усны шинжилгээ – Микробиологийн үзүүлэлт			1	100	100	MNS 6561:2015 Ариутгах татуургын хамжээнд нийлүүлэх хаягдал ус ТЕШ
Хөрсний бохирдол							
3.1	Хөрсний шинжилгээ – Агро хими	Төслийн талбайд 2 цэг	Жилд нэг удаа	1	28	28	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2029 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.2	Хөрсний шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/	Төслийн талбайд 2 цэг			99	99	
3.3	Хөрсний шинжилгээ – Биохими	Төслийн талбайд 2 цэг			85	85	
Нийт						511.0	

ДҮГНЭЛТ

2025 оны төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 4,850.000 нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд 3,750.000 төгрөг, осол эрсдэлийн төлөвлөгөөнд 2,260.000 төгрөг, хог хаягдлын төлөвлөгөөнд 4,380.000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 511.000 төгрөг нийт **15,751.000** төгрөг зарцуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 3,547.000 нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд 5,100.000 төгрөг, осол эрсдэлийн төлөвлөгөөнд 1,920.000 төгрөг, хог хаягдлын төлөвлөгөөнд 2,406.700 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 206,800 төгрөг нийт **13,180.500** төгрөг зарцуулан ажиллав.

ХАВСРАЛТ 1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ

ХАВСРАЛТ 2 НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ

ХАВСРАЛТ 3 ОСОЛ ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ

ХАВСРАЛТ 4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ

ХАВСРАЛТ 5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН БАРИМТ